

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234737

ӨВӨР МОНГОЛЫН ЯРУУ НАЙРАГЧ АРТАЙН УРАН БҮТЭЭЛИЙН
СУДАЛГААНЫ ТОЙМ, ОЛОЛТ

Б.Тогтомж
Д.Өрнөхдэлгэр

Түлхүүр үг: Артай, эх орон, уянгын зохиол, шүлэг, яруу найраг

Артай 1949 онд Өвөр Монголын Өөртөө Засах орон (ӨМӨЗО)-ы Шилийн гол (монгол бичгээр - sili-yin γoul, *шили-ийн гоул*; хят. 錫林郭勒 - *xīlínguōlè*) аймгийн Дайфүши (太仆寺旗 Tàipúsi Qí) хошууны Гүнбулаг сумын малчны гэрт төржээ. Аав ээжийнхээ хайр халамжаар өсөж торнисон Артай бээр 1956 оны алтан намар Гүнбулаг сумын бага сургуулийн босгыг алхаж, 1962 онд Бээжингийн дунд сургуульд шалгуулан орсон байна. 1964 онд сургуулийнхаа “Улаан залуус” сонины найруулагчаар ажиллаж байхдаа шүлэг бичиж эхэлжээ. 1965 оны намар Шулуун хөх хошуу (正藍旗 Zhènglán Qí)-ны Шандын гол дунд сургуульд шилжин суралцаж, 1968 онд нутагтаа буцаж, ажил хөдөлмөр эрхлэх болов. 1971 онд Ардаас эрхэлсэн сургуулийн орлогч багш болсны хамт Гүнбулаг сумын ажлын чөлөөний Улаанмөчирийн зохион бүтээгчийн ажлыг хавсран “Гүнбулагийн дуулал” хэмээх тосон барын сэтгүүлийг гурван хугацаа эрхлэн найруулжээ. Эдгээр нь түүний “анхны үеийн утга урлагийн үйлдэл” байсан ажээ.

1973 онд тэр Өвөр Монголын монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургууль буюу одоогийн Хөххот үндэсний дээд сургуульд шалгуулан ороод, 1975 онд сургуулиа төгсөж, Шилийн гол аймгийн Соёлын товчоонд ажилд оржээ. 1978 онд Өвөр Монголын утга урлагийн холбооны “Өнөр цэцэг” сэтгүүлийн хороонд шүлгийн найруулагчаар ажиллаж, 1984-1986 онд Өвөр Монголын их сургуулийн зохиол судлах ангид суралцсан байна. 1985 онд Дундад улсын зохиолчдын эвлэлд элсэн, 1988 онд Өвөр Монголын зохиолчдын эвлэлийн дэд тэргүүлэгчээр сонгогдсоны дээр “Өнөр цэцэг” сэтгүүлийн дэд ерөнхий найруулагч болж, 1997 онд Өвөр Монголын зохиолчдын эвлэлийн байнгын дэд тэргүүлэгчээр шилжин ажиллаж, 1999 онд Өвөр Монголын утга урлагийнхан холбооны дэд тэргүүлэгчээр сонгогдон, 2004 оны 12 сард Өвөр Монголын утга урлагийнхны холбооны тусгай тушаалт дэд тэргүүлэгч, Зохиолчдын эвлэлийн тэргүүлэгчээр сонгогджээ. 2005 оны 1 сард Өвөр Монголын утга урлагийнхны холбооны намын удирдах дугуйлангийн гишүүн болж 2010 онд гавьяаны амралтанд гарчээ.

Анхны шүлэг “Худаг малтагчдын дуулал”-аа 1966 оны 4 сарын 3-ны өдрийн “Өвөр Монголын өдрийн сонин”-нд нийтлүүлжээ. 1972 онд бичсэн “Салж ядсан сэтгэл” нь уншигчдын сэтгэлд хүрэн, 1983 онд нийтлүүлсэн “Монгол гэр” шүлэг нь хоёрдугаар хугацааны бүх улсын цөөн тоот үндэстний утга зохиолын бүтээлийн “Ажнай” шагнал хүртэж, 1983 онд бичсэн “Бодлын цэнхэр яргуй” шүлэг, 1988 онд бичсэн “Үхэрчин” шүлэг нь Өвөр Монголын Өөртөө засах орны утга урлагийн хамгийн дээд шагнал “Солонго” шагналын тэргүүн шагнал хүртсэн байна.

Тэрбээр “Далавчтай морь”, “Артайгийн шүлгийн сонгомол”, “Давлагаан”, “Тугалын бэлчээр”, “Бодлын цэнхэр яргуй”, “Артайгийн хүүхдийн уран зохиолын сонгомол”, “Артайгийн шинэ шүлгийн сонгомол”, “Артайгийн шүлгийн сонгомол”, “Артай монгол салхи”, “Артайгийн шүлгийн сонгомол” (Хятад хэлээрх хэвлэл), “Миний хөдөө”, “Сэтгэл урлагийн зай” зэрэг номоо хэвлүүлсэн. Тэр дундаас “Бодлын цэнхэр яргуй”, “Артайгийн шинэ шүлгийн сонгомол” нь дөрөвдүгээр, зургаадугаар хугацааны цөөн тоот үндэстний утга зохиолын бүтээлийн “Ажнай” шагналыг хүртэв. “Артайгийн шинэ шүлгийн сонгомол” нь 1999 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орны “Таван нэг инженерин” шагнал, “Артай монгол салхи” нь 2011 онд “Дорно” утга зохиолын шагнал хүртэв.

2016 оны I сард “Өнөрцэцэг” сэтгүүлийн хэвлэл эрхэлсэн 60 жилийн ойг дурсан тэмдэглэх их хуралд Артай “Гавьяат зохиолч” цол хүртсэн. Хэсэг бүтээлүүд нь ХХ зууны далаад оноос дунд сургууль, их сургуулийн заах материалд сонгогдон, өнгөрсөн зууны наяд оноос оюутан, сурагчдын төгсөх өгүүллийн сэдэв болсны хамт нэг бүлэг шүүмжлэгч, эрдэмтдийн судлагдахуун болсон байна. Олон бүтээл нь дотоод гадаадад орчуулагдан, ард олны дунд өргөн дэлгэрсэн билээ.

Тэрээр уран зохиол туурвилаараа үл барам дотоод гадаадын шилдэг уран бүтээлүүдийг орчуулж, 1986 онд Америкийн шүлэгч Уолт Уйтмены шүлгийн түүвэр “Өвс навчны түүвэр”-ийг орчуулж, 1987 онд “Үрэлтийн зохиолын сонгомол” (Хишигтогоотой хамтран орчуулсан), “Дундадын профессор Нью-Йоркт”, “Нобелийн шагналт шүлэгчдийн шүлгийн сонгомол” зэргийг орчуулжээ.

1993 онд Улсын нэгдүгээр дэсийн зохиолчоор үнэлэгдэн, Дундад улсын зохиолчдын эвлэл хийгээд Зунхува утга зохиолын суурь мөнгөнөөс голлон эрхэлдэг “Жувэн Жүн Вен утга зохиолын шагнал” хүртэж, 1994 онд Төрийн явдлын хорооны “Засгийн ордны онц харамж”-ийг хүртэгч мэргэжилтнээр үнэлэгдэж, 1995 онд Өөртөө засах орны “Хөдөлмөрчийн жишээч”-ээр сонгогдов. 2001 он, 2006 он, 2011 онд болсон Дундад улсын зохиолчдын эвлэлийн зургаадугаар, долоодугаар, наймдугаар удаагийн бүх улсын төлөөлөгчдийн их хурал дээр Дундад улсын зохиолчдын эвлэлийн тэргүүлэгчдийн бүлгэмийн гишүүнээр сонгогджээ. 2010 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орны Засгийн ордноос олгодог “Уран зохиолын үйлст гавьяа зүтгэл үзүүлсэн алтан медаль” хүртэж, 2012 онд Дундад улсын шүлгийн нийгэмлэгийн гуравдугаар хугацааны бүх улсын төлөөлөгчдийн их хурал дээр нийгэмлэгийн дэд даргаар сонгогдов.

БНХАУ-ын монгол үндэстний яруу найрагчдын дотроос Артайн яруу найргийг өндрөөр үнэлэн үздэг билээ. Тэрээр амьдрал, цаг үеийн ороо бусгааг дүрслэн шүлэглэхдээ үнэн зүрхнийхээ гүнээс сүсэглэн, үзгийн хурц, ухааны нарийн ураар амилуулан бичихдээ гарамгай нэгэн. “Нутгаа гэсэн мөнх халуун үзэл, эх орныхоо төлөө гэсэн чин сэтгэлтэй эгэл

найрагч”¹ гэж өөрийгөө тодотгодог энэ уран бүтээлчийн туурвил зүйн онцлогийг тодруулан судлах нь туйлын сонирхолтой бөгөөд нэн чухал юм.

Артай, Төрийн шагналт яруу найрагч, ӨМӨЗО-ны Улсын нэгдүгээр дэсийн зохиолч хүн. Тэр 1949 онд Шилийнгол аймгийн Тайбусе хошууны Гүнбулаг сумын Шаварт гацааны нэгэн малчны гэрт төржээ. 1975 онд Өвөрмонголын хэл бичгийн тусгай мэргэжлийн сургуулийн сурлагын хугацаагаа төгсөөд Шилийнгол аймгийн Соёлын товчоонд ажиллаж байснаа 1978 онд “Өнөр цэцэг” сэтгүүлийн хороонд ирж найруулагч болжээ. Энэ зуур тэрбээр Өвөрмонголын их сургуулийн утга зохиол судлах ангид орж суралцсан байна. Одоо Өвөрмонголын утга урлагийнхны холбооны дэд тэргүүлэгч, Зохиолчдын эвлэлийн тэргүүлэгчээр ажиллаж буй.

Артай, монгол үндэстний алдарт шүлэгчийн нэгэн болох замналаа 1966 онд ууган шүлэг “Худаг малтагчдын дуулал”-ыг нийтэлснээс эхлээд урьд хожид “Бодлын цэнхэр яргуй” (1990), “Шүлгийн зоог” (2004), “Артай монгол салхи” (2008) зэрэг арваад номоо туурвиж У.Уйтмений “Өвс навчны түүвэр” зэрэг ном бүтээлүүдийг монгол хэлнээ орчуулж хэвлүүлсэн байна. Түүний зохиол бүтээл олон нийтийн өндөр үнэлэлтийг олж, урьд хожид Төрийн шагналыг гурван удаа гардсан. Утга зохиолд үзүүлсэн гарамгай зүтгэлээрээ “Зован зүн вэн утга зохиолын шагнал”-ыг хүртсэн бөгөөд орны шагналыг арваад удаа, эл сонин сэтгүүлийн шагналыг олонтаа тосож явсан байна. Тэр бас “Өвөрмонголын гурван их залуу зохиолч”, “Тэргүүний хувь хүн” зэрэг яруу алдрыг хүртэж явсан түүхтэй. Түүний зохиол бүтээл нь хятад, солонгос, япон, англи, араб, орос зэрэг хэл болон кирил үсэг дээр орчуулагдан буулгагдаж, гадаад дотоодын уншигчдын өндөр үнэлэлтийг олсон байна.

Артай, монгол чөлөөт шүлгийн гол төлөөлөгч мөн. 1980-аад онд тэр чөлөөт шүлгийн өвөг багш гэгдсэн Америкийн шүлэгч Уйтмений “Өвс навчны түүвэр”-ийг хятад орчуулгаас монгол хэлээрээ анх орчуулж, монгол уншигчдынхаа харааг тэлж, оюуныг нээгдүүлсэн байна. Мөн тухайн үеэс эхлэн тэр шүлэг бүтээлдээ хэлбэрийн чөлөөт байдлыг эрхэмлэжээ. “Уйтмэн шиг агуулга нь ч хэлбэр, хэлбэр нь ч агуулга маягийн шүлэг бичих”² даруй агуулга болон хэлбэрийн харилцан уялдаат нэгдлээр үелзсэн дотоод сэтгэлгээний айзмаар хэмнэлээ болгосон чөлөөт шүлэг бичихийг зорьж байв. Мөн тухайн үеэс эхлэн тэр “Бодлын цэнхэр яргуй” мөчлөг шүлгээ туурвиж эхлэв. Энэхүү шүлгүүд нь “Бодит ертөнцийн дүрслэл болон нийгэм ахуйн байдал (1970-аад оны эхний үеийн шүлгүүд)-аас алгуур холдож, бодит ертөнцийн гүн ухаанлиг, уянга яруугаар тоочих зүгт хэлбийж, сүр жавхаатай үсрэлт ихтэй чөлөөт хэлбэрээр цоройж³ боссон байдаг.

Монгол орон, ард түмэн, үндэстнийхээ гурамсан нэгдлийг шүлгийнхээ үндсэн агуулга, утга сэдвээ болгож “Эх орондоо шүлэг бичье л гэж төрсөн...”⁴ найрагчийн нэг бол Артай билээ. Яриангүй, “Эхийн тухай шүлэг бичээгүй шүлэгч хорвоод бараг оршихгүй. Учир нь эх хүн гэж хүний эх юм. “Эх”-гүй

¹ Артай (2022). “Арц” хэмээх сурвалжлага найрууллын VI боть. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, тал 7

² Сүеэ (2008), “Монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүх”, Хөх хот, Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо, тал 209

³ Мөн тэнд, тал 208

⁴ Артай (1990), “Бодлын цэнхэр яргуй”, (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, тал 10

бол бид эхэлж үл чадна. Эх гэж миний амь насыг төрж өсгөсөн “байгаль” буюу “нутаг”, шүлгийн мөнхийн сэдвийн нэг”⁵ нь болдог. Тэгэхэд шүлэгч Артайн эдгээр бүхнийхээ төлөө санааширч явдаг эзэн хүний санаашрал, эзэн хүний тунхаглалаас гадна бас ирээдүйдээ хариуцах хариуцлагат сэтгэлээр цаг үргэлж гадаад ертөнцийн муу муухай буюу үндэстний болхи бүдүүлэг зан чанарыг үнэнчээр илчлэн ташуурдаж, сэхээрүүлэн сануулж явдаг. Шүлэгчээс “Монгол шүлэг бол бороо зурвахсан ч, зүсрээд өнгөрсөн ч бороо юм шүү. Монгол хүн, тал хоёр барилдах юм шүү!”, “Борооны дундуур өнгөрсөнд би шал нортлоо дуулаад гүйдэг байсан. Одоо би энэ бороон дунд шал нортлоо уйлаад зогсдог боллоо!”⁶ гэж шүлэглэсэн байдаг. Энэ нь түүний “Монгол номд бэлчих нүд малд явах хүн шиг цөөрч байгаа өнөөдөр исгэгдэж, элсэхэрхэгжиж, наймаалагдаж байгаа газар шороо, энэ газар шорооноос ургасан зориг санаа, золбоо хийморь, мөхлөг мөхлөгөөр, дусал дуслаар монгол үсэг рүү нүүж байгаа...”⁷ зэрэг эдгээр нүүдлүүдийн араас нулимс цайран бараадаж, сэтгэл алгасан байгаагийнх нь илрэл байжээ. Шүлэгчийн иймэрхүү гадаад ертөнцийн тэгш бус, болхи муухайн төлөө тулан эсэргүүцдэг зориг сөс, итгэл мөрөөдөл, хүсэл мөрөөдлийг нь дурдууштай.

Яруу найргийн хэл хэллэг юуны өмнө урсам, яруу, хөгжимлөг байхыг шаарддаг. Яруу найраг нь уянгалаг байдлаараа бусад утга зохиолын төрөл зүйлээс ялгагддаг. “Үг хэл бол өгөгдөөгүй тоо мөн, хэм хэмжээ бол хязгааргүй эрх чөлөө мөн”⁸ гэдгээр Артай дотоод сэтгэлийн айзам хэмнэлийг ихэд чухалчилдаг. Тэрээр “Аялгуу, сэтгэлээр амьсгална. Сэтгэлгээ, хэллэгээр илэрнэ. Хэллэгээс хөгжимлөг шинж илэрнэ”⁹ гэсэн байдаг. “Шүлэг бол нот нь илгүй дуу мөн, шүлгийн нот бол даруй түүний үсэг, айзам, хэмнэл, өргөлт, холбоц нь мөн” иймэрхүү нотгүй дууны аялгуу нь даруй сэтгэл болно. Шүлэгчийн шүлэгт “Сэтгэлгээний үүсэл, өрнөл, оргил, намдал, асгарлыг дагаж долгиолсон их сайхан айзам байдаг”¹⁰. Мөн ч энэхүү айзам сэтгэлгээ нь шүлгийн хэл хэллэгээс улбаатай юм. Энэхүү хэл хэллэг нь яриагүй амьд хөдлөнгүй мөртөө бас шинэ соргог байх нь лавтай. Найрагч хэлэхдээ “Яруу найраг бол аливаа бусад ч оршихуйд дүр төрх, зан чанар хайрладаг урлаг мөн” бөгөөд “Шүлгийн мөр дэх нэг үгийг нүдний харцаар хөндөөд авахад энэ шүлгийг хөдөлгөж, эхэлнэ - хөдөлгөөндөж эхэлнэ” гэсэн байдаг. Мөн ч энэхүү зан чанаржсан, дүр төрхөжсөн үг хэлнээс хөгжимлөг шинж үүсдэг буюу! Тухайлбал, Артайн “Амьтан”, “Миний үг” шүлгүүдэд:

“Загас булгийг хөгжимдөж байна

Тогос будгийг хөгжимдөж байна.

Эр бор харцагай уулын ханан хадыг хөгжимдөж байна

Эх байгалийн найрал хөгжмийн эгшиг нь намайг хөгжимдөж байна”¹¹ гэсэн бөгөөд бас

⁵ Б.Буянхишиг: “Нэг өгүүлэгдэхүүн далан дөрвөн өгүүлэхүүн”, Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2006, тал 36.

⁶ Хайрхан: “Эзэн хүний тунхаг, эр хүний уянга”, “Тоонот нутаг” ерөнхий нэгдүгээр хугацаа. тал 269.

⁷ Артай: “Сэтгэл урлагийн зай”, “Өнөр цэцэг”, 2008,12. тал 53.

⁸ Буянхишиг, Б. (1990). “Өрөөсөн сар”, Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, тал 334.

⁹ Артай (2004). “Шүлгийн зоог”, Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо, тал 218.

¹⁰ Артай (2004). “Шүлгийн зоог”, Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо, тал 219.

¹¹ Артай (2008). “Артай монгол салхи”, Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, тал 115.

“Агар (хад)-ын ирмэгээр миний үг сүүтэй ярилцаж сууна.

Сүү инээгээд нааш цааш донхолзож зудын шившгийг элэглэнэ.

Анжисны толиор миний үг газартай ярилцаж явна.

Газар энгэрээ ярж намрын тухай бичсэн баян шүлгээ гайхуулна...” гэсэн байна. Эндээс бид шүлэгч “хөгжимдөж”, “ярилцаж, хөөрөлдөж...” зэрэг үйл үгээр шүлгийн хэл хэллэгээ зан төрхжүүлж, уншигчдын сэтгэлд өвөрмөц уянгалаг аясыг дээжилсэн байгааг харж болно.

Түүний шүлэг бүтээлийн тухай өгүүлэл шүүмж олон байдаг боловч бүх талын системтэй судалгааны бүтээл хараахан хомсхон байсаар. Иймээс бид Артайн шүлэг бүтээлийг ерөнхийлөн ажиглаж, түүний шүлгийн өвөрмөц онцлогуудыг илрүүлэхийн өмнө уран бүтээлийн судалгааны тойм ололтыг тодруулан үзэхийг зорилоо.

Артайн шүлэг бүтээлийн судлалаас түүний сүрлэг идрүүн өвөрмөц хэв намбыг илрүүлэхийн хамт бас түүний эх орон, ард түмэн, үндэстэндээ дээжилсэн хайр сэтгэлийг нь мэдрэхээр барахгүй түүний монгол шүлэгт үзүүлсэн хувь нэмрийг ч тодорхойлох учиртай. Эндээс бид Артайн шүлгийн үнэ цэнийг мэдэж болно.

Яруу найраг бол утга зохиолын эрдэнийн суварга дээрх гэрэлт сувд билээ. Эх хэлээрээ шүлэг бичиж, уншигчдынхаа хайр талархлыг хүртэнэ гэдэг ариун дээд яруу алдар байх ёстой. Артай хэдэн арван жил шүлэг бичээд, эх хэлнийхээ зохион бүтээх хөгжлийг ахиулсан төдийгүй монгол үндэстний утга зохиолын эрдэнэсийн санг баяжуулсан уран бүтээлч хийгээд утга зохиолд оруулсан хувь нэмрийг олноос хүртсэн сайн сайхан үнэлэлт сайшаалаараа шинэ Дундад улсын анхны үеийн шүлэгчдийн төлөөлөгч Н.Сайнцогтын дараа хоёрдугаар үеийн монгол үндэстний шүлэгчдийн төлөөлөгч хэмээн үнэлэгдсэн билээ.

“Дэлхийдээ би хайртай

Дээр нь миний Монгол хэл бий”,

“Монгол хэлээрээ шүлэг бичих-

Энэ бол миний амьдран орших хэлбэр

Энэ бол миний үхэхгүй өвчин”¹² гэж ухамсарлан эх нутаг, ард түмэндээ ухаангүй хайртай энэ шүлэгч найргийнхаа аяндаа хэдийгээр ганцхан удаа шүлэг бүтээлийнхээ тухай судлан ярилцах хурал хийсэн боловч түүний шүлэг бүтээлийн тухай өгүүлэл шүүмжүүд цөөнгүй байдаг. Сонин сэтгүүл дээр нийтлэгдсэн тусгай өгүүлэл шүүмжүүдийг бүртгэвэл бараг 30 илүү байна. Эдгээр шүүмж өгүүлүүдийг хураангуйлбал доорх байдал харагдаж байна.

Нэг. Артайн шүлгийн тухай бичиж нийтэлсэн тусгай шүүмжүүд нийт 19 байна. Тухайлбал, Намжилцэвээн “Үнэлүүштэй нэгэн шүлэг” (Өвөр монголын “Өдрийн сонин”, 1975, 8, 11), Дорнотэнгэр “Оюун сүнсний бослого” (“Өнөр цэцэг”, 2008, 12), Мянгад Эрдэмт “Ирэх зууны босгон дээр алт давтагч - Артайн орчмын шүлгүүдийн тухай” (“Монгол хэл утга зохиол”, 1994, 4), Ё. Билигбаатар “Торгон иртэй сэтгэхүй” (“Шилийн гол”, 1998, 3), Одонбилиг “Монгол гэрээр сэдэвлэсэн хоёр шүлгийн харьцуулал” (“Алтан түлхүүр”, 1985, 6), Чин Шан “Дуртгал ба мөрөөдлийн уулзварт эвхэрсэн сэтгэлгээний уянга” (“Өнөр цэцэг”, 1999, 9), В. Сайнцогт “Яруу найраг ба сэхээрүүлэл” (“Өнөр цэцэг”, 1993, 11), М.Цэдэнбал

¹² Артай: “Шүлгийн зоог”, Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо, 2004, тал 25.

“Яруу найргийн төрөлжил” (“Өнөр цэцэг”, 1992, 6), Х.Буянбат “Шүлгийн шүлэглэлдүүн - Артайн “Тэр миний шүлэг”-ийг уншаад” (Өвөр монголын “Өдрийн сонин”, 1983, 10, 12), Ж. Ринчиндорж “Хутаг буюу найраг” (“Шилийн гол”, 1998, 2), Т.Сэцэн “Шинэ сэвүүн «Тал» - Артайн «Тал» гэдэг шүлгийн тухай” (Өвөр монголын “Өдрийн сонин”, 1983, 4, 20), С.Урсгал “Урлагийн өргөн хараа уянгын өвөрмөц тогтолцоо –Артайн шүлгийн түүвэр «Бодлын цэнхэр яргуй»-н тухай” (“Өвөр монголын Залуучууд”, 1995, 6), Н.Шаравжамц “Өвөрмөц сэтгэмжтэй «Говийн гоо»” (“Өнөр цэцэг”, 1984, 3), С.Насандалай “Магтууштай шүлэг” /Артайн эр зоригийн магтуу/ (“Өнөр цэцэг”, 1982, 5), Ө.Начин “Дөрвөн шүлэг хийгээд дөрвөн өчүүхэн төрөгдөл” (“Алтан түлхүүр”, 1994, 3), А.Хасбулуу “«Эр зоригийн магтуу» лугаа эгч дүү шүлэг – Артай нөхрийн «Амьдрал сайхан» шүлгийг уншаад” (“Өвөр монголын залуучууд”, 1983, 5), Б.Нарс “Тоо сайхны хөөцөлдөл - нөхөр Артайн хэдэн шүлгийг уншсан тэмдэглэл” (“Алтан түлхүүр”, 1994, 4), Ласагмаа “Задгай шүлгийн илрүүллийн гоо сайхан - Артайн «Дурлал» гэдэг шүлгийг сонирхоод” (“Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2005, 1) зэрэг шүлэг бүтээлийн тусгай шүүмжүүд байна. Эдгээр шүүмжийн гол агуулга нь “Салж ядсан сэтгэлгээ”, “Бүлээн чулууны нулимс”, “Монгол гэр”, “Бодлын цэнхэр яргуй” (түүвэр), “Эр зоригийн магтуу”, “Говийн гоо”, “Морь”, “Даатгал”, “Амьдрал сайхан”, “Хөдөөгийн үдэш”, “Тал”, “Тэр миний шүлэг” зэрэг дан ганц түүвэр буюу хэдэн шүлгийн тойронд үнэлэлт хийж, түүний хэл хэллэг, уран сэтгэмж, хэлбэр урлахуйн ололт, арга барилын туршиц буюу алдаш оношоос нь өөрийн үзэлт танилт, сэтгэгдэл төрөгдлөө илтгэсэн байдаг. Энд бид төлөөлүүлэн хоёр шүүмжийг товч танилцуулахад.

1) Дорнотэнгэрийн “Оюун сүнсний бослого - Артайн «Бодлын цэнхэр яргуй» гэх шүлгийн түүврийн тойронд” (“Өнөр цэцэг”, 2008, 12) шүүмж нь “Бодлын цэнхэр яргуй” түүврийн чөлөөт хэлбэр, боргожуун (эгэл энгүүн) хэллэг ба хүрхэрсэн (оргилсон) сэтгэлгээ зэрэг талаас Артайн шүлгийн бусдаас онцлогдох найргийн сэтгэлгээний хэлбэр ба найргийн итгэл буюу найргийн алс ирээдүйн үзэлтийг бичсэн байна.

2) Мянгад Эрдэмтийн “Ирэх зууны босгон дээр алт давтагч - Артайн орчмын шүлгүүдийн тухай” (“Монгол хэл утга зохиол”, 1994, 4) utvty өгүүлэл нь Артайн 1991-1993 оны хооронд нийтлэгдсэн “Хөх давсны талст”, “Бороотой өдөр”, “Холын цастай уул”, “Морь”, “Газар шороо”, “Би энд ирлээ” зэрэг шүлгийн тухай өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байна. Энд шүүмжлэгчийн цаг, орон зайн давалт хийгээд холбон бодолтын дүүлэл буюу бясалгахуйн гүнээс үүссэн сэтгэлийн хүч, нутаг амьтай сэтгэлгээ ба ирээдүйн тухай санаашрал зэргийг бичсэн байна.

Хоёр. Артайн яруу найргийн тухай судлаачдын хэвлүүлсэн нийтлэл, өгүүлэл гэвэл, Хайрханы “Эзэн хүний тунхаг, эр хүний уянга”, Х.Буянбатын “Артайн «Бодлын цэнхэр яргуй»-н уран сэтгэмж”, “Шинэ соргог «Бодлын цэнхэр яргуй»”, Г.Буяндэлгэрийн “Артайн шүлгийн хэл хэллэг хийгээд уран сэтгэмж”, “Сэтгэмж нь гүн санаа нь ханагар - «Бодлын шүүдэр»-ийг уншаад”, Т.Сэцэнбаярын “Дотоод бүтэц ба цогцын эсгэмжийн нарийлаг холбоо - шүлэгч Артайн шинэ бүтээлийн амтархал”, Я.Цагаанмөрөний “Эх хэлний үзүүрээс дусагнасан сүү”, “Хязгааргүйн дундуур дураар эргэсэн шүлэг”, С.Баярын “Артайн орчмын

шүлгүүд ба шүлгийн урлаг”, Д.Эрдэнэбаганын “Артай, Ч.Мэргэний шүлэг дэх найруулгын гоо зүйн тухай”, Хасуул, Хадац Гангийн “Үхэр тэрэг, од, сар”, Л.Жаргалын “Яруу найргийн яруу хэм ба Артайн уянгын намба”, Содгэрэлий “Шүлэгч Артайн зохиол бүтээлд илэрсэн үндэстний тухай үзэл санааны анхан ажиглалт” зэрэг 13 байна. Эдгээр өгүүлүүдэд Артайн шүлгийн хэл хэллэг, уран сэтгэмж, холбон бодолт, хэлбэр, үндэстний тухай, хэмнэл холбоц, хэв намба зэрэг талаас судалсан байна. Доор бид хоёр өгүүллийг нь сонгон товч тайлбарлавал,

1) Хайрхан “Эзэн хүний тунхаг, эр хүний уянга” (“Тоонот нутаг”, ерөнхий нэгдүгээр хугацаа) гэсэн өгүүлэлдээ, “Артай бол шинэ эриний монгол шүлгийн чухал нэгэн төлөөлөгч болно. Артайн уран бүтээлийн шинэ эриний гучин жилийн монгол шүлэг бүтээлийн эрлийн мөр, үүдлийн сураг, хөгжлийн хандшийг төвлөрүүлэн үзүүлж, агуулга, хэлбэр, урлаг эл талаар нэгэн үеийн шүлгийн суртлыг төлөөлсөн юм”¹³ хэмээн дүгнэжээ. Энэхүү өгүүлэл нь эх орны эзэн хүний омогшил, ардач үзэл, оюунч зориг санаа, туульслаг хөөцөлдөл, монгол чөлөөт шүлэг ба оршиж байгаа асуудал зэргийн зургаан хэсгээс бүрэлдсэн байна.

2) Ё. Цагаанмөрөний “Эх хэлний үзүүрээс дусагнасан сүү” (“Өнөр цэцэг” 2007.11) өгүүлэлд Артайн шүлгийн сэтгэлгээний онцлогийг эрэлхийлсэн байна. Энэхүү сэтгэлгээ нь даруй “Нойтон цагаан сэлмээр шулуулж явсан” эгэл энгүүн үнэнч уламжлалт амьдралын бүтээгдэхүүн болохыг тодорхойлон гаргажээ.

Гурав. Үүнээс гадна Артайн шүлэг бүтээлийн тухай өгүүлэл шүүмж буюу ойлголт төрөгдлүүд Сүеэгийн найруулан зохиосон “Монгол үндэстний уран зохиолын түүх” (одоо үе), (Лионингийн үндэстний хэвлэлийн хороо, 1997 он), “Монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүх” (Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо, 2008 он) зэрэг утга зохиолын түүхийн номд шилэгдэж орсноор барахгүй бас Х.Буянбат “Монгол шүлгийн одон зурхай” (Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1989 он), Хайрхан “Шинэ эриний монгол шүлэг дэх өнөөгийн урсгал бүлэг” (Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2003 он), Мянгад Эрдэмт “XX зууны 80, 90-ээд оны монгол шүлэг туужсын судлал” (Үндэстний хэвлэлийн хороо, 2004 он) зэрэг утга зохиолын тусгай судлалын ном бүтээлүүдэд ч олонтоо сонгогдон орсон байдаг.

1960-аад оноос эхэлж зохиол бүтээлээ туурвиж эхэлсэн Дундад улсын Монгол үндэстний яруу найрагч Артайн яруу найргийг дагнан судалсан судлаач эрдэмтэн Дундад улсад цөөнгүй. Түүний яруу найргийн “Артайн шүлгийн түүвэр” дэх зарим шүлгийг задлан шүүмжлэн, сэтгэлгээний онцлог хийгээд яруу найргийн ертөнц дэх үзэл хандлага, санааг илэрхийлэн бичжээ. Түүний бүтээлийг үнэлж дүгнэн бичсэн хүмүүсийн дотроос В.Сайнцогт нь “Артайн яруу найраг ба сэхээрүүлэл” хэмээх өгүүлэл бичихдээ, “Яруу найргийн сэхээрүүлэл нь хэдийгээр зөвхөн соёлын хөдөлгөөн төдий л боловч, соёлын хөдөлгөөний түлхэн ахиулах үйлдэлгүй бол ямарваа хувьсгалын үйлдэл нь ялалт олж чаддаггүй билээ”¹⁴ гэсэн нь яруу найрагчийн гадаад илрэлийг бус дотоод сэтгэлгээний илрэлийг түлхүү авч үзсэн нь илт. Түүний яруу найргин тухайд бичсэн хүмүүсийн ихэнх нь “Артай бол Дундад улсын Монгол үндэстний

¹³ Хайрхан: “Эзэн хүний тунхаг, эр хүний уянга”, “Тоонот нутаг” ерөнхий нэгдүгээр хугацаа. тал 52.

¹⁴ В.Сайнцогт “Артайн «Морь»-ийг шүүмжлэх нь”, “Өнөр цэцэг” сэтгүүл, 1993, 11-р хугацаа

гарамгай яруу найрагч” гэсэн дүгнэлтийг ихэвчлэн хийсэн байна. В.Сайнцогтоос түүнийг “Шүлэг бичихдээ ихэвчлэн эх орон үндэстнээ хайрлах, энэ биеэ зориулах уламжлалт зориг санаа нь түүний шүлэгт ерөөс гол сэдвээ болгож иржээ. Түүний үндэстэн эх орноо хайрлах санаагаа шүлэг, яруу найргаараа түүнийгээ илэрхийлэн гаргасны дотроос “Явья”, “Үүр хаяарч байлаа”, “Шүлэг минь бос” зэрэг нь шилдэг”¹⁵ гэж Артайн яруу найргийн зарим онцлогийг задлан шинжилсэн нь түүний уран бүтээлд өгсөн томоохон үнэлэлт болно.

Тухайн үеийн шүлэгч зохиолчид “магтаал дуулал”-ыг эрхэм болгон туурвиж байсан бол, “1979 онд Л.Одцэрийн “Сумьяа”, Б.Бүрэнбэхийн “Хүслэнгийн хүлэг” шүлэг нийтлэгдсэнээс “магтаал дуунд үндсэн эргэлт гарч, “шарх сорви”, “бодолгошрол” хэмээгдсэн, “гунигт жүжиг”-ийн өнгө үнэр бүхий шүлгүүд гарч шинэ нэг хөг аясыг нэмэн, одоо үеийн монгол шүлгийн хөгжлийнхөө хувь дахь шижир үедээ орсон”¹⁶ байна. Артайн шүлэг нь XX зууны 70-аад оноос 80-аад оны эхэн үе хүрч ирэхэд магтаал зураглалаас алгуур холдож, ахуйн халамжлал, эргэцүүлэл тунгаалт буюу сэтгэл алгасал зүг шилжсэн. Энэ нь түүний зохиол бүтээлийнх нь боловсролтын цаг үе болно. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь түүний яруу найрагт өгсөн судлаач, шүүмжлэгчдийн үнэлэлт, дүгнэлт билээ.

Их байгалийн эвдэгдэл, эх нутгийн замхрал, уламжлалт соёлын балрал, баатар зоригийн хугарал зэрэг нь хүмүүсийн сэтгэлд тэсвэрлэж чадашгүй гуниг, уйтгарлалыг авчирч өгсөнтэр цаг үед “цаг үеэ алганы зураас шигээ таньсан хүн сая цаг үедээ айхтар им тамгатай танигддаг байж таарна”¹⁷ хэмээн тухайн үеийн монгол шүлэг бүтээлүүд нь сэдвийн талаар өнгөрсөн үеэсээ баялагжиж, нэлээд тооны шүлэгчид огтхон ч хөндөгдөөгүй сэдэв - амь оршихуйн утга сэдэвт бийр дүрж, үзгээ хурцлан, билиг оюунаа хүрэлцэж билээ. Үүний толгойлогчийн нэг бол Артай болно.

Артайн шүлэг бичих гол онцлог үгийн утга, уран дүрслэл, хэл хэллэгээ янз янзаар нээхийг эрмэлзэн, хурц дүрслэлийг ил далд хэлбэрээр бүтээлдээ тусгасан нь зөвхөн нэг зүйлд баригдалгүй чөлөөтэй сэтгэж санасан бодсоноо яруу сайхан уянгалуулан бичдэг. Түүний шүлэглэх айзам хэмнэл, мөр бадгийн хоорондын уялдаа зэргээс үзэхэд чөлөөтэй сэтгэж, үгийн сэлгэлт нь гоё чамин үгэнд баригдалгүй энгийн хэллэг ашиглан, түүнийгээ шүлгийн мөрөндөө гайхалтайгаар шигтгэдэг онцлогтойг судлаачид тэмдэглэжээ.

Утга зохиол бол хэлний урлаг мөн. Яруу найргийг хүмүүс утга зохиолын доторх уянга яруу эгшиглэл хэмээдэг билээ. Тиймээс яруу найргийн хэл нь юуны өмнө урсам уянгалаг, яруу хөгжимлөг байхыг шаарддаг. XX зууны 60-аад оны эхээр Г.Буянбатаас шүлгийн хэл хэллэг нь “Уран тод, урсам ялгуун, амьдлаг сайхан байх”-ыг уриалж байсан бол 80-аад онд Б. Бүрэнбэх профессор “Уянгын эрэлчний тэмдэглэл”-дээ шүлгийн хэллэг нь “амьд дүрслэг, шаргаамал хурц, уянга сэтгэлгээ, хөгжимлөг байх” хэрэгтэй хэмээн дөрвөн талаар тодорхойлсон байна. Энэ нь шүлгийн хэл хэллэг нь “Урсам яруу, уран тод”-оос улам нэг алхам дээшилж, “Уянга сэтгэлгээ, хөгжимлөг байх”-ыг шаардах болсон байна. Мөн профессор Сүеэгэ, “Шүлгийн хэл хэллэгийг үг үсгийн гадаад шинж, үгсийн

¹⁵ В.Сайнцогт “Артайн «Морь»-ийг шүүмжлэх нь”, “Өнөр цэцэг” сэтгүүл, 1993, 11-р хугацаа

¹⁶ Сүеэгэ: “Монгол үндэстний уран зохиолын түүх” (Одоо үе), (М), Шяонинг, Лионингийн үндэстний хэвлэлийн хороо, 1997 он. р40

¹⁷ Ё.Билигбаатар: “Торгон иртэй сэтгэхүй”, (J), “Шилийн гол”, 1998, 3. р99

сангийн утгаас шинжлэхээс гадна бас сэтгэлгээний өнгө, санааны хандлага, гоо сайхны илэрхийлэл, онцгой илрүүлэх уран чадвар, сэрэл сэдэлт зэрэг дотоод шинжээс очиж ажиглах чухаллан тэмдэглэсэн байдаг. Ингэж гэмээн сая амьд урсангуй байдаг шүлгийн хэл хэллэгийн нуугдмал шидийг бүрэн илрүүлж чадна”¹⁸ гэж улам нэг алхам тодорхой болгон өгүүлсэн бөгөөд шүлгийн хэл хэллэгийг сэрэл сэдэлт, сэтгэлгээ зэрэгтэй уусган шингээж судлан шинжлэхийг хичээсэн байна. Тиймээс шүлгийн хөгжимлөг шинж нь тун чухал байдаг, тэр нь шүлгийн бусад төрлийн зохиолоос ялгагдах чухал нэгэн онцлог мөн хэмээн зөвшөөрдөг. Артай уламжлалт шүлгийн холбоц, хэмнэл зэргээр шүлгийн хөгжимлөг шинжийг жигдрүүлэн, шүлгээ яруу сонсголонтой болгодог бөгөөд бас чөлөөт сэтгэлгээний айзам, үйл үгийн хэрэглээг чадварлагаар ашиглан шүлгийн хөгжимлөг шинжийг чангаруулан, шүлгээ огцом хүчтэй, сүрлэг идрүүн болгодгоороо бусдаас ялгаатайг дээрх судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг.

“Нэгэн үндэстний шүлэг нь тэр үндэстнийхээ ярианы хэлнээс амь нас олдог, үүний зэрэгт тэр үндэстний ярианы хэлэнд амь нас олгодог”¹⁹ хэмээн алдарт шүлэгч Томас Элиот хэлсэн байдаг. Тийнхүү нэг шүлэгч буюу зохиолч нь тэр үндэстнийхээ үг хэл үсэг бичиг, нэн ялангуяа тэр үндэстнийхээ элбэг баялаг ярианы хэлээ сайтар эзэмших ба ашиглах нь туйлын чухал байдаг.

Артайн уран бүтээл дэх өгүүлсэн шүлэг нь хэдийгээр эртнээс уламжлалтай боловч тэр нь хүмүүсийн сэтгэлд нэвтэрч чадаагүй буюу хөгжлийн шатандаа хүрч чадсангүй. XX зууны 40-өөд оны үеэр хэдийгээр “Арвин сан”, “Зовлонгоос салсан Дагва лам” гэх мэтийн өгүүлсэн шүлгүүд бичигдсэн боловч тийм амжилттай болж чадсангүй. 50-60-аад оны үеэр өгүүлсэн шүлэг хөгжлийнхөө оргил үедээ ирсэн бөгөөд монгол шүлгийн хүрээ хэмжээнд шинэ уур амьсгалыг авчирсан юм. “Өгүүлсэн шүлэг хүүрнэлийн хувьд хүний дүрийг бүтээж, үйл явдал гаргах хэрэгтэй. Шүлэг гэгдсэний хувьд уянгалаг шинж, уран таавар, хийсвэр сэтгэлгээ зэрэг байх хэрэгтэй”²⁰ байдаг. Даруй “Нандир, Сүмбэр хоёр”, “Лусын хаадын хурим”, “Өлзийжаргалын дурдатгал”, “Сумьяа” зэрэг олон шүлгүүд дараалан бий болж уншигчдын сонирхлыг татаж байсан тэр цаг үед яруу найрагч Артай өгүүлсэн шүлгүүдээ туурвисан байдаг. Тухайлбал:

“Бичгийн хүн ээ, чи нааш ир!

Би чамд хоёр үг хэлье!” гэж

Буурай болсон улаан халцгай хүрээнээс

Бадамрай адил нэг юм дуугарлаа.

...

Гэвч би журам нэрд даатгаж

Хээнцэр бүхнээ энэ хөрсөнд өргөнө

Гэдэс нь цадсан энэ бууц харин

Гэдрэг намайг хорвойлгох санаа нь харамсалтай...”²¹.

¹⁸ Сүеэгэ: “Монгол үндэстний уран зохиолын түүх” (Одоо үе), Шяонинг, Лионингийн үндэстний хэвлэлийн хороо, 1997 он. тал 40.

¹⁹ Жин Гэ: “Уран зохиол урлаг” (хятад хэлээр), (М), Дундад улсын хөгжлийн хэвлэлийн хороо, 2006 он. р96

²⁰ Сүеэгэ: “Монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүх” (доорд), (М), Хөх хот, Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо, 2008 он. тал 27.

²¹ Артай: “Давлагаа”, (М), Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо, 1986 он. р249

“Эх дэлхийтэйгээ элэг нэг” явдаг шүлэгчид маань байгаль дэлхийтэйгээ сэтгэлээрээ холбогдож, тэднийхээ гуниг зовлонг сэтгэлдээ тээн, жаргал зовлонгоо хамтатгаж явдаг. Дээрх “Нэргүй цэцэг” шүлэгт уянгын хүүрнэлийг голлож, “хуучин бууцан дээр хоцорсон өнчин цэцэг”-ийн яриагаар нийгэм дэх “Сүүний хариуд хөө буцаадаг” муу муухай зан чанарыг хилэгнэн илчилсэн байна. “Өгүүлсэн шүлэг эрхбиш өгүүлэх (үлгэрээ ярих) дундаа уянгалж, уянгалах дундаа өгүүлэхийг нягт уялдуулбал сая сайн өгүүлсэн шүлэг болж чаддаг”²² гэдэг. Тухайлбал, “Талд ургасан үлгэр” хэмээх шүлэгт:

“Би хятад шүү, та итгэхгүй байна уу?

Битгий инээ, уг нутаг Шандун юм шүү” гэж

Бие мэхийн саалийн архи бариад

Бялхуултал хэмнэж миний өмнө тавьчлаа”²³

хэмээн шүлэглэсэн нь тал нутгийн ард түмний минь цайлган цагаан өрөвч сэтгэлийг харуулснаар барахгүй чөлөөлөгдсөний дараах Дундад улсын элүндэстний ард түмний эе найрамдуу жаргалант шинэ амьдралыг магтан дуулсан байна.

Артай нэлээд шүлэгтээ цөм иймэрхүү уянгын хүүрнэлийг уусган шингээсэн байдаг. Тухайлбал, түүний “Хавар надтай уулзаад”, “Шүтээн уулын магнай”, “Хоёр улиас”, “Яахав дээ...”, “Үхэрчин”, “Хиймэл дагуул”, “Дурлал”, “Монгол хүн бол архи уу”, “Соёл” зэрэг шүлгүүд нь хүүрнэл уянгын хөг аясаар баялаг болжээ. Эдгээр шүлгүүд нь амьдралаас үүсэж, амьдралд суурилж тухайн цаг үеийн байдлаа тодруулан тусгасан нь үнэнтэйгээр барахгүй түүний шүлэгт өвөрмөц гэрэл гялбааг авчирч, эгэл энгийн аясаар уншигчдын сэтгэлийг уяруулан долгисуулдаг байна.

Ер нь “баян хэл гэдэг нь миний үзэхээр тольд үгүй хүчир үг буюу шүлгийг чинь үзээд толь эргүүлж эрэх л хэрэгтэй гэсэн үг биш, харин эгэл жирийн уран зохиолын хэлээр гүн утга, ёгт санаагаа гаргачихвал болчихно гэж бодож буй”²⁴ гэж үздэг. Гэтэл энхүү “Эн жирийн уран зохиол”-ын хэлийг ус цас шиг гойд хэрэглэх бол шүлэгч зохиолчдын нэг хоёр өдрийн зүтгэл биш гэдэг нь мэдээжийн хэрэг бишийг шүүмжлэн өгүүлсэн байна.

Артайн шүлэгт орсон үг бүхэн бүр өөр өөрийн хувийн жинтэй байж, үсэг бүхэн түүний сэтгэлгээг тээж явдаг. Тэр сонгосон үгсээ шүлгийнхээ эцэс буюу сүүлийн хэсэгт “булж” тавьдаг. Жишээлбэл: “Миний үг” гэх шүлэгт:

Агарын ирмэгээр миний үг сүүтэй ярилцаж сууна -

Сүү инээгээд нааш цааш дунхалзаж зудын шившигийг элэглэнэ.

Анжисны толиор миний үг газартай ярилцаж явна -

Газар энгэрээ ярж намрын тухай бичсэн баян шүлгээ гайхуулна.

Алиа салхин миний үгээр модны навчтай ярилцаж өнгөрөөнө -

Навч баярлаж цэцэрхээд “Би чамд хайртай шүү!” гэж нулимс бөмбөрүүлнэ.

Агтын туурай миний үгээр шилийн чулуутай ярилцаж давхина -

Чулуу оч бутартал хөгсөж “Би чамд баярлалаа” гэж дээр

²² Чи.Мэргэн: “Монгол шүлгийн тухай”, (М), Хайлаар, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1990 он. р40

²³ Артай: “Давлагаа”, (М), Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо, 1986 он. р175

²⁴ Чи.Мэргэн: “Монгол шүлгийн тухай”, (М), Хайлаар, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1990 он. р38

дээр үсэрнэ²⁵ гэх мэтээр “сууна, элэглэнэ, явна, гайхуулна, өнгөрнө, бөмбөрүүлнэ, давхина, үсэрнэ” зэрэг үгээ шүлгийнхээ мөрийн хамгийн эцэст тавьж, бүх шүлгээ хөдөлгөөнжүүлж, дүржүүлэн уншигчдынхаа сэтгэлийн гүнд хадаж тавьдаг. Мөн “Намрын бороо” хэмээх шүлэгт:

*Ширүүн зантай намрын аадар
Догшин шилбүүр эргүүлж
Сүүжийн овооны баруун дээгүүр
Хэсэг адуу тууж байна.
Сэлмээ гялалзуулсан ихэмсэг аянга
Сэхээ чөлөөгүй зандчиж
Сэтгэлийн хайрт Улаан нуурыг минь
Албын бүжиг үсрүүлж байна²⁶*

гэх мэтээр “ширүүн зантай намрын аадар” (хашир адуучин) шилбүүр эргүүлэн адуугаа тууж явах ба “сэлмээ гялалзуулсан аянга” (хашир сургагч) сэхээ чөлөөгүй зандчиж, “Улаан нуур”-ыг албаар бүжиг үсрүүлж байх нь хараанд тодорч, явах тутам ойртож байх буюу эсхүл өөрөө ч шүлгийн ертөнцөд нь орчхоод адуугаа тууж явж байх ч шиг санагддаг. Үүнд шүлэгчийн амьдралын нарийн ажиглалт ба уран сэтгэмж хэрэгтэй ч мөн “эргүүлж, тууж байна”, “зандчиж, үсрүүлж байна” зэрэг нь үйл үгсийн гойд хэрэглээ нь шүлгийг нэн хурц болгосон ч хэт чамирхалд хүргэсэн үнэнтэй. Түүний “Тэнгэр нуур” хэмээх шүлэгт, “Хээр нэрсэн архи, дээр өргөсөн гэм, өдөржин ховдоглож шимсэн нар, өглөө босохдоо ч нүүр нь ув улаан гэнэ шүү. Сар харин сайн ч уудаг хүүхэн. Гэе (гэтэл) сардаа хэд удаа шал согтож ойччихоод хундаган дотор нь хөвдөг гэнэ шүү”²⁷. Энд шүлэгч “ховдоглож шимсэн”, “согтож ойччихоод” хэмээх дөрвөн үйл үгээр шүлгээ хөдөлгөөнд оруулж чадсан бөгөөд уншигчдын ой тойнд “архинд халсан, согтсон”, “нар, сар”-ны тиймэрхүү дэгжин цовоолог дүрийг бүтээсэн байдаг онцлогтой. Ер нь “шүлгийн мөрөн дэх нэг үгийг нүднийхээ харцаар хөндөөд авахад энэ шүлгийг хөдөлгөж эхэлнэ. Хөдөлгөөнтөж эхэлнэ”²⁸ гэж шүлэгч хэлсэн байдаг. Эдгээр шүлгүүд нь даруй түүний уран бүтээлийн нэг онцлог болдог байна.

Түүний “Шөнө” хэмээх шүлэгт:

*Шөнө –
Сараа дэврэгсээр
Оддоо дагасаар ирдэг²⁹*

гэж шүлэглэсэн билээ. Энд зөвхөн нэгэн жижигхэн хэсгээс эшилсэн боловч энэхүү хэсэгт шүлэгчийн амьдралын гярхай ажиглалт ба содон сэтгэмжийг харуулдаг мөртөө бас үгсийн сонголтын охь шилдэг байхыг үзүүлдэг. Иймэрхүү сонголт, ажиглалт, охь шим нь манай монгол шүлэгчдийн дунд бас хааяа тохиолддог. Тухайлбал:

²⁵ “Артай монгол салхи” (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2008 он. Р99

²⁶ Артай: “Бодлын цэнхэр яргуй”, (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1990 он. р176

²⁷ Артай: “Бодлын цэнхэр яргуй”, (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1990 он. р49

²⁸ Артай: “Шүлгийн зоог”, (М), Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо, 2004 он. р218

²⁹ Артай: “Бодлын цэнхэр яргуй”, (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1990 он. р118

*Цонхны гадна
навч унаж
намар унаж
нам жим унаж
Цоожстой сэтгэлийг
шөнийн салхи үе үе
сүүрс алдсаар мөргөлхийлэн унана...*³⁰.

Энд шүлэгчээс “унаж” гэсэн энгийн үйл үгээр “навч, намар, уйтгар” алив бүхэн унасан байхад “ганц миний үүдэн дээрх зүрхэн дээрх өнөөх оньс л унахгүй байж”, “түлхүүрийн дууг чагнасан, ганцаархнаа суусаар л байлаа”. Ер нь “шүлэг зохионо гэдэг нь үг хэлний хязгаарыг тэлж, “үг бүтээх” бололцоог өргөтгөх нарийн будилаантай явц юм. Санаа хэдий сайн байж, айзам хэдий сайхан байлаа ч түүндээ зохицох үгийн оноолтгүй болвоос шүлэг болж үл чадна”³¹ гэдэг. Тиймээс яруу найрагч нэг л үгээр шүлгээ амилуулдаг увдистай байдаг. Үүнийг даруй үгийн содон оноолт гэдэг.

Загас булгийг хөгжимдөж байна.

Тогос будгийг хөгжимдөж байна.

Эр бор харцгай

Уулын ханан хадыг хөгжимдөж байна.

*Эх байгалийн найрал хөгжмийн эгшиг нь намайг хөгжимдөж байна*³².

Тус хэсэгт “хөгжимдөж” гэсэн үйл үг онцгой байна. Дундад улсын эртний шүлэг өгүүлэгчдийн үзэхээр шүлэгт “Шүлгийн нүд” байдаг гэдэг. Тэрхүү “шүлгийн нүд” нь тус шүлгийг амилуулсан ганц хоёр үгийн оноолт дээр бий гэдэг билээ. Тухайлбал, “Улаангүйлсний мөчир намиан дор хаврын санаа үйммүй” гэсэн мөрөнд “үйммүй” гэдэг үг нь нэгэн дуугүй зүйлсийг агшин зуур аялга дуу оруулан, хүмүүст харааны сэрлээс сонорын сэрэл зүг шууд нэвтрэн, чихэнд сонссон шиг санагддаг гэдэг³³. Тиймээс миний үзэхээр тус хэсэг дэх “хөгжимдөж” гэсэн үг нь ч “нүд” нь болдог гэж үздэг. Тэр нь хараа болон сонорын сэрлийг нэвтрүүлэн, бүх шүлгийг амьд хөдлөнгүй болгодог байна. Тэгвэл доорх “Саамгай” шүлэгт:

“Үзэмчин нутгийн малчид үнээ л саадаг биш

Өргөн талаас тос саана

Өндөр даралттаас гэрэл саана

Өнгөрсөн түүхээс нулимс саана

Өнгөрөөгүй цагаас инээд саана...”³⁴ хэмээн шүлэглэж “саах” гэдэг үйл үг бол малчин ардын өдөр тутмын амьдралд холбогдох маш нарийн хөдөлгөөнийг заасан үг болно. Тэр нь идэг идгээр (бага багаар) сүүгээ шувтарч авах хөдөлгөөнийг хэлдэг. Шүлэгч энд “саах” гэсэн үйл үгийг тэлэн, малчин түмнийхээ “өнгөрсөн, одоо,

³⁰ Ван Гүэ Ви (2007), “Хүний ертөнцийн үг хэл” (хятад хэлээр), (М), Жилингийн утга зохиол түүхийн хэвлэлийн хороо, тал 64

³¹ Буянхишиг, Б (2006) “Нэг өгүүлэгдэхүүн далан дөрвөн өгүүлэхүүн”, (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, тал 54

³² “Артай монгол салхи” (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2008 он. p115

³³ Ван Гүэ Ви: “Хүний ертөнцийн үг хэл” (хятад хэлээр), (М), Жилингийн утга зохиол түүхийн хэвлэлийн хороо, 2007 он. p11

³⁴ Артай: “Артайн шинэ шүлгийн сонгомол”, (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998 он. p50

ирээдүй”-н уудам зайгаас аливаа бүхнийг саан, үлдээн, эзэмшиж авахыг хүсэн мөрөөдсөн байна. Ер нь: “үйл үгийн уран нарийн хувиллаар шүлэг юүгээ байнгын «хөдөлгөөн»-ий байдалд оруулах «боргожуун» нь хол давуу байдаг”³⁵ нь энэ биз.

Хүний нийгмийн аж төрлийн гүн нарийн утга учир, жам зүйг яруу тодорхой дүрслэн илэрхийлж, хүний сэтгэлийг догдлуулан хөдөлгөж хүмүүжүүлэх зорилгоор үндэсний хэлний бүхий л баялаг, хамаг боломж сэлтийг уран дүрслэлд хэрэглэсэн үг яриаг уран зохиолын хэл гэнэ³⁶. Уран зохиолын хэл бол утга зохиолын хэлний хамгийн олон янзын найруулгыг багтаасан, төгс, баялаг, төгөлдөр хэлбэр нь мөн бөгөөд түүнийг хөгжүүлэхэд туйлын чухал учир холбогдолтой үг яриа юм³⁷. Иймээс зохиолын чанар, агуулга, уран сайхны тухай ярихдаа түүний бие цогцсыг бүтээгч тулгуур бол хэл, уран сайхны талаар авч үзэх нь чухалтай бөгөөд дээрх судлал шүүмжийн өгүүлүүд чухам энэ талыг нээж илрүүлэхэд анхаарсан байна. Артай нь эх хэлээрээ яруу найраг бичдэг цөөн тоот монгол үндэстний нэг тул түүний яруу найргийн хэл, уран сайхан нь маш торгомсог үгийн сангийн далайгаас эрдэнэс шүүрэх шиг тийм яруу байдаг. Гоё дэгжин үг, элдэв чимэглэлд баригдалгүй энгүүн үг хэллэгийг өргөн дэлгэр ашиглан уран сайхны дүрслэлд нийцүүлдэг нь гайхалтай. Артайн шүлэг дэх хэлний дүрслэг шинж нь, “монгол тоотны хэл ер нь гайхалтай дүрслэг байсаар ирсэн бөгөөд ялангуяа яруу найргийн хэл нь түүний охь сүлд болж хүмүүст амтархагдсаар ирсэн. Аль ч үндэстний соёл өнгөрсөн – одоо – ирээдүйтэй байдаг. Гэхдээ одоогийн хүн нь өнгөрсөн ба ирээдүйг холбосон амьд тэнхлэг байдаг”³⁸. Артай бол тэдгээр тэнхлэгүүдийн нэгэн билээ. Түүний Дундад улсын монгол үндэстний дунд яруу найргаараа оруулсан хувь нэмрийг тодруулах мөн түүний уран бүтээлийг монгол уншигчдад түгээн дэлгэрүүлэх, судалгааг улам гүнзгийрүүлэх нь хилийн чанад дахь монгол туургатны уран зохиолын хөгжилд нэн чухал юм.

³⁵ Б.Буянхишиг: “Нэг өгүүлэгдэхүүн далан дөрвөн өгүүлэхүүн”, (М), Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2006 он.р52

³⁶ Гаадамба, Ш. (1989). *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар, тал 100

³⁷ Мөн тэнд тал 101

³⁸ Өвөр монголын утга зохиолын тавин жил (1997). Дээд дэвтэр. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

Ном зүй

- Артай, (2008). “Артай монгол салхи”, Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо
- Артай, (1998). “Бодлын цэнхэр яргуй”, Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо
- Артай, (2008). “Сэтгэл урлагийн зай”, “Өнөр цэцэг” Өвөр монголын ардын хэвлэлийн хороо
- Артай, (2004). “Шүлгийн зоог”, Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо
- Буянхишиг, Б. (1990). “Өрөөсөн сар”, Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо
- Буянхишиг, Б. (2006). “Нэг өгүүлэгдэхүүн далан дөрвөн өгүүлэхүүн”, Хөх хот, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо
- Сайнцогт, В (1993). “Артайн «Морь»-ийг шүүмжлэх нь”, “Өнөр цэцэг” сэтгүүл
- Сүеэ, (2008). “Монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүх”, Хөх хот, Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо
- Хайрхан, “Эзэн хүний тунхаг, эр хүний уянга”, “Тоонот нутаг” ерөнхий нэгдүгээр хугацаа.

Abstract

Considering the theme of Artai's poem, the poet of the Mongolian ethnic group, a small minority in China, he has a “mine” that preserves the great energy of the motherland and the people, as well as love, happiness and sadness. Every time you read Artai's poems, you will be overwhelmed by the power of magic, that is embedded in every line of the poem. This is the awakening of thought and the power of language. Writing poetry in Mongolian is a praise of his today's great merit. There are quite a few poems with a simple tone and style in Artai's poetry. However, those poems with simple language are written with a deep meaning towards the people and the nation. His artistic language, which contains the color of the Mongolian mentality, teaches about the love of Mongolian traditions and heritage. Artai writes poems without forgetting the nation, state, and people. Moreover, he is a poet who writes wonderful poems as a part of his country's whole life. Those people, who are a part of the great history, breathe the sacred air of their country from the magical words written in poetry in order to preserve their national culture, history, literacy, and customs.

Keywords: Artai, motherland, lyrics, poetry, study